



“Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт

## ҮНЭТ ЦААСНЫ КЛИРИНГИЙН ЖУРАМ

## АГУУЛГА

1 НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	.....
2 НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .....	.....
3 КЛИРИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	.....
4 КЛИРИНГИЙН ГИШҮҮН.....	.....3
5 БАРЬЦАА, МАРЖИН .....	.....8
6 СААТАЛ .....	.....9
7 ДЕФОЛТ, ДЕФОЛТЫН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ.....	.....10
8 ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ САН .....	.....12
9 БУСАД .....	.....14





## Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК (цаашид “Клирингийн төв” гэх)-ийн гүйцэтгэх үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа, клирингийн гишүүнчлэл болон дефолтын үед хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын арга хэрэгзэлтэй холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2 Үнэт цаасны клирингийн үйл ажиллагааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалт, энэ журам болон энэ журамд нийшүүлэн Клирингийн төвөөс гаргасан заавар, клирингийн үйл ажиллагаанд оролцогч талуудтай байгуулсан гэрээний хүрээнд зохион байгуулна.
- 1.3 Энэ журам болон түүнд орох нэмэлт өөрчлөлтийг Төлөөлөн удирдах зөвлөл баталж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх) батламжилна.

## Хоёр. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
  - 2.1.1 “Арилжаа эрхлэх байгууллага” гэж үнэт цаасны арилжааны клирингээ Клирингийн төвөөр гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх этгээдийг;
  - 2.1.2 “Барьцаа” гэж үнэт цаасны клиринг төлбөр тооцоо гүйцэтгэх, эрсдэлийг удирдах зорилгоор Клирингийн гишүүнээс Клирингийн төвийн дансанд байршуулах мөнгөн хөрөнгө болон Клирингийн төвийн хүлээн зөвшөөрсөн үнэт цаасыг;
  - 2.1.3 “Дефолт” гэж энэ журмын 7 дугаар бүлэгт заасан нөхцөл үүссэнийг;
  - 2.1.4 “Зөвшөөрөгдсөн үнэт цаас” гэж арилжаа эрхлэх байгууллага болон Клирингийн төвийн хооронд харилцан зөвшөөрсний үндсэн дээр клиринг гүйцэтгэх үнэт цаасыг;
  - 2.1.5 “Их дунтэй арилжаа” гэж нэг хэлцлийн эсвэл нэг хэлцэлтэй адилтгаж болох хэд хэдэн хэлцлийн үнийн дүнгийн нийлбэр нь 100 сая төгрөгт хүрсэн, эсвэл нэг төрлийн үнэт цаасны 5-аас дээш хувийг арилжсан хэлцлийг;
  - 2.1.6 “Клирингийн төвийн ажлын өдөр” гэж Клирингийн төвийн жилийн хуанлид тусгагдсан ажлын өдрийг;
  - 2.1.7 “Клирингийн төвийн систем” гэж Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5.1.4-т заасан дэд бүтцийг;
  - 2.1.8 “Клирингийн төвийн хөрөнгийн эхний хэсэг” гэж саатал эсвэл дефолтын үед зарцуулахаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хөрөнгийг;
  - 2.1.9 “Клирингийн төвийн хөрөнгийн нэмэлт хэсэг” гэж дефолтын үед зарцуулахаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хөрөнгийг;
  - 2.1.10 “Маржин” гэж харилцагчаас үнэт цаас худалдан авахаар Клирингийн гишүүний дансанд байршуулсан урьдчилгаа төлбөрийг;
  - 2.1.11 “Мөнгөн төлбөрийн болон үнэт цаасны шилжүүлгийн даалгавар” гэж Клирингийн төвөөс боловсруулан Клирингийн гишүүнд хүргүүлсэн Үргийг;
  - 2.1.12 “Саатал” гэж энэ журмын 6 дугаар бүлэгт заасан нөхцөл үүссэнийг;



- 2.1.13 “Төлбөр гүйцэтгэх байгууллага” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх этгээдийг;
- 2.1.14 “Төлбөрийн баталгааны сан” гэж энэ журмын 8 дугаар бүлэгт заасан сантажийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг;
- 2.1.15 “Үнэт цаасны төлбөр тооцоо” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг;
- 2.1.16 “Хадгаламжийн байгууллага” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэх этгээдийг;
- 2.1.17 “Харилцагч” гэж арилжаа эрхлэх байгууллагын гишүүн УЦК-д арилжааны данс нээлгэсэн иргэн, хуулийн этгээдийг;
- 2.1.18 “Цэвэршүүлсэн дүн” гэж Клирингийн гишүүний үнэт цаас тус бүрээр тодорхойлсон мөнгөн төлбөрийн болон үнэт цаасны шилжүүлгийн цэвэр дүнг;
- (ТҮЗ-ийн 2020 оны 19-р тогтоолоор өөрчлөн найруулсан)

## Гурав. КЛИРИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Клирингийн төв нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

- 3.1.1 Арилжаа эрхлэх байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр арилжааны баталгаажсан хэлцлийг хүлээн авч, мөнгөн төлбөрийн болон үнэт цаасны шилжүүлгийн даалгаврыг цэвэршүүлсэн дүнгээр боловсруулж, холбогдох байгууллагад илгээх;
- 3.1.2 Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, энэ журам болон клирингийн гишүүнтэй байгуулсан гэрээнд үндэслэн барьцаа авах, төлбөрийн баталгааны сан бүрдүүлэх, тэдгээрийг захиран зарцуулах замаар үнэт цаасны клиринг гүйцэтгэх, төлбөр тооцооны хэвийн тасралтгүй байдлыг дэмжин ажиллах;

3.2 Үнэт цаасны клиринг дараах дарааллаар явагдана. Үүнд:

- 3.2.1 Арилжаа эрхлэх байгууллагаас үнэт цаасны арилжааны баталгаажсан хэлцэл хүлээн авах;
- 3.2.2 Баталгаажсан хэлцэлд үндэслэн мөнгөн төлбөрийн болон үнэт цаасны шилжүүлгийн даалгавар боловсруулж, Клирингийн гишүүн болон төлбөр гүйцэтгэх байгууллагад илгээх;
- 3.2.3 Клирингийн гишүүний байршуулах барьцааны дүнг тодорхойлж гишүүнд мэдээлэх;
- 3.2.4 Төлбөр гүйцэтгэх байгууллагаас мөнгөн төлбөрийн эсвэл үнэт цаасны шилжүүлгийн гүйцэтгэлийн тайланг төлбөр гүйцэтгэх хугацаа дууссан даруй хүлээн авах;
- 3.2.5 Энэ журмын 3.2.4-д заасан тайланд Клирингийн гишүүн мөнгөн төлбөр эсвэл үнэт цаасны шилжүүлгийг гүйцэтгээгүй тухай мэдээлэгдсэн тохиолдолд түүнд saat ал гарсан эсэхийг энэ журмын 6 дугаар бүлэгт заасны дагуу, дефолтийн нөхцөл үүссэн эсэхийг энэ журмын 7 дугаар бүлэгт заасны дагуу тус тус тодорхойлж, холбогдох арга хэмжээг авах;

## Дөрөв. КЛИРИНГИЙН ГИШҮҮН




- 4.1 Өөрийн болон харилцагчийн үнэт цаасны данс, төлбөр тооцооны бүртгэлийг хөтөлж, Клирингийн төвөөс тодорхойлсон мөнгөн төлбөрийн болон үнэт цаасны шилжүүлгийн үүргийн гүйцэтгэлийг хангах эрх зүйн болон үйл ажиллагаа санхүүгийн чадвартай хуулийн этгээдийг Клирингийн гишүүн гэнэ.
- 4.2 Клирингийн төв гишүүнчлэлтэй байх бөгөөд Клирингийн гишүүн нь дараах төрлөтэй байна. Үүнд:
  - 4.2.1 Өөрийн харилцагчийн болон Клирингийн бус гишүүний мөнгөн төлбөр болон үнэт цаасны шилжүүлгийн үүргийг Клирингийн төвийн өмнө хүлээх Клирингийн ерөнхий гишүүн;
  - 4.2.2 Зөвхөн өөрийн харилцагчийн мөнгөн төлбөр болон үнэт цаасны шилжүүлгийн үүргийг Клирингийн төвийн өмнө хүлээх Клирингийн шууд гишүүн;
  - 4.2.3 Зөвхөн өөрийн харилцагчийн мөнгөн төлбөр болон үнэт цаасны шилжүүлгийн үүргийг Клирингийн ерөнхий гишүүний өмнө хүлээх Клирингийн бус гишүүн;
- 4.3 Клирингийн ерөнхий гишүүн нь 10 хүртэл Клирингийн бус гишүүний клиринг, төлбөр тооцоог гэрээгээр гүйцэтгэж болно.
- 4.4 Клирингийн бус гишүүн зөвхөн нэг Клирингийн ерөнхий гишүүнтэй гэрээ байгуулж ажиллана. Хэрэв өөр Клирингийн ерөнхий гишүүнтэй гэрээ байгуулах бол өмнөх гэрээгээ цуцалж, тооцоо дуусгасны үндсэн дээр шинэ гэрээ байгуулна.
- 4.5 Клирингийн гишүүн дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
  - 4.5.1 Хорооноос үнэт цаасны зах зээл дээр зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байх;
  - 4.5.2 Клирингийн ерөнхий гишүүн 3.0 тэрбум төгрөгөөс доошгүй, Клирингийн шууд гишүүн 1.0 тэрбум төгрөгөөс доошгүй өөрийн хөрөнгөтэй байх;
  - 4.5.3 Хорооны тогтоосон эргэлтийн хөрөнгийн харьцааны шалгуур хангасан байх;
  - 4.5.4 Клирингийн ерөнхий гишүүн болон Клирингийн шууд гишүүн 2-оос доошгүй, Клирингийн бус гишүүн 1-ээс доошгүй клиринг төлбөр тооцоо хариуцсан орон тооны ажилтантай байх;
  - 4.5.5 Клирингийн төвийн системд холбогдох техникийн боломжтой байх;
  - 4.5.6 Үйл ажиллагааны журамтай байх, уг журамд клиринг, төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцох, харилцагчаа танъж мэдэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийг хэрэгжүүлэх, дотоод хяналт, комплаенсын тухай тусгасан байх;
  - 4.5.7 Мэдээлэл солилцох албан ёсны хаяг, суурин утастай байх;
  - 4.5.8 Банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;
  - 4.5.9 Төлбөрийн чадваргүйд тооцогдсон эсвэл Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан Онцгой нөхцөл байдлын тохиолдол бий болоогүй байх;
  - 4.5.10 Энэ журамд заасан барьцаа, маржин, төлбөрийн баталгааны сангийн шаардлагыг ханган ажиллахыг зөвшөөрсөн байх;



- 4.5.11 Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн холбооны гишүүн байх;
- 4.6 Энэ журмын 4.5-д заасан шаардлагыг хангасан этгээд дараах баримт бичгийн бүрдүүлэн Клирингийн төвийн гишүүнээр элсэх хүсэлт гаргана. Үүнд:
- 4.6.1 Клирингийн гишүүнээр элсэх хүсэлтээ илэрхийлсэн албан бичиг;
  - 4.6.2 Хуулийн этгээдийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон компанийн дүрмийн хуулбарууд;
  - 4.6.3 Хүсэлт гаргагч этгээд бизнесийн нэгдэлд хамаардаг бол харилцан хамааралтай болохыг нотлох баримт;
  - 4.6.4 Хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан;
  - 4.6.5 Гишүүний элсэлтийн хураамж төлсөн баримт;
  - 4.6.6 Үнэт цаасны клирингийн үйл ажиллагаанд оролцох санхүүгийн чадвартай буюу энэ журмаар хүлээсэн төлбөр тооцоо, барьцаа, төлбөрийн баталгааны сангийн хуримтлалын болон бусад үүргийг гүйцэтгэх чадвартай болохыг нотолсон баримт;
  - 4.6.7 Үйл ажиллагааны журам, клирингийн ерөнхий гишүүний хувьд клирингийн бус гишүүнтэй байгуулах гэрээний төсөл;
  - 4.6.8 Журмын 4.5-т заасан шалгуурыг хангаж байгааг нотлох зорилгоор Клирингийн төвөөс шаардсан нэмэлт баримт бичгүүд;
- 4.7 Клирингийн төв нь энэ журмын 4.6-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан хянаж, хүсэлт гаргагч этгээдийг клирингийн гишүүнээр элсүүлэх эсэх тухай шийдвэр гарган, албан бичгээр хариу мэдэгдэнэ.
- 4.8 Хүсэлт гаргагч этгээд энэ журмын 4.6-д заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд ирүүлсэн өдрөөс эхлэн энэ журмын 4.7-д заасан хугацааг тооцно.
- 4.9 Хүсэлт гаргагч этгээд энэ журмын 4.6-д заасан баримт бичигт орсон аливаа өөрчлөлтийн тухай энэ журмын 4.7-д заасан хугацаанд Клирингийн төвд албан бичгээр нэн даруй мэдэгдэнэ.
- 4.10 Клирингийн гишүүн элсүүлэх тухай шийдвэрийг Клирингийн төвийн Захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэн Гүйцэтгэх захирал гаргана.
- 4.11 Клирингийн гишүүнээр элсүүлэх тухай шийдвэр гарснаас хойш ажлын тав хоногт багтаан гишүүнчлэлийн гэрээ байгуулна.
- 4.12 Дараах тохиолдолд Клирингийн төв хүсэлт гаргагч этгээдийг клирингийн гишүүнээр элсүүлэхээс татгалзана. Үүнд:
- 4.12.1 Хүсэлт гаргагч нь энэхүү журмын 4.5-т заасан шаардлагыг хангаагүй;
  - 4.12.2 Энэ журамд заасан баримт бичгийн бүрдүүлбэр бүрэн бус;
  - 4.12.3 Ирүүлсэн мэдээлэл болон баримт бичгүүд нь хуурамч эсвэл төөрөгдүүлсэн;
  - 4.12.4 Хүсэлт гаргагч, түүний хөрөнгө оруулагч эсвэл толгой компанийд төлбөрийн чадваргүй байдлын хэрэг үссэн эсвэл хугацаа хэтэрсэн өр төлбөртэй;



- 4.12.5 Хүсэлт гаргагч, түүний хяналтын багц эзэмшигч, толгой компани эсвэл гүйцэтгэх удирдлага гэмт хэрэгт шалгагдаж байгаа болон шүүхийн шийтгэх тогтоолоор ял шийтгэл эдэлж байгаа нь тогтоогдсон;
- 4.13 Клирингийн гишүүнээр элсүүлэхээс татгалзсан тохиолдолд Клирингийн төвд ирүүлсэн баримт бичгийг хүсэлт гаргагч этгээдэд буцаан олгохгүй.
- 4.14 Клирингийн гишүүнээр элсүүлэхээс татгалзсан шийдвэр гарснаас хойш 45 хоногийн дараа хүсэлт гаргагч дахин шинээр хүсэлт гаргаж болно.
- 4.15 Клирингийн төв дараах эрхтэй. Үүнд:
- 4.15.1 Клирингийн гишүүнд тавигдах шалгуурыг шинэчлэн тогтоох, уг шалгуурын хэрэгжилтэд хяналт тавих, энэхүү журам болон гэрээнд заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд Клирингийн гишүүнд авах арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх;
  - 4.15.2 Клирингийн гишүүнээс барьцаа авах, барьцааны хөрөнгийг энэ журам болон гишүүнчлэлийн гэрээнд заасны дагуу захиран зарцуулах;
  - 4.15.3 Төлбөрийн баталгааны сан байгуулах, удирдах, холбогдох журмын дагуу захиран зарцуулах, өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;
  - 4.15.4 Саатал, дефолтын үед хэрэгжүүлэх арга хэмжээ, тэдгээрийн дараалал, үйл ажиллагааг тодорхойлон хэрэгжүүлэх;
  - 4.15.5 Клирингийн гишүүний төлөх хураамж, шимтгэл, алдангийн хэмжээг тогтоох, нэхэмжлэх;
  - 4.15.6 Нэхэмжилсэн төлбөрийг барагдуулаагүй Клирингийн гишүүний Клирингийн төвийн дансанд байршуулсан барьцаа хөрөнгийг нэхэмжилсэн төлбөрт тооцон сутгах;
  - 4.15.7 Төлбөрийн баталгааны сангийн хуримтлал байршуулаагүй Клирингийн гишүүний арилжааг зогсоох мэдэгдлийг арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх;
  - 4.15.8 Клирингийн гишүүн болон түүний харилцагчийн төлбөрийн эрсдэлийг тооцоолох зорилгоор холбогдох мэдээллийг гишүүнээс шаардах;
- 4.16 Клирингийн төв нь дараах үүрэгтэй. Үүнд:
- 4.16.1 Энэ журам болон Клирингийн төвийн системд орох нэмэлт өөрчлөлтийг Клирингийн гишүүнд урьдчилан танилцуулсны үндсэн дээр нэмэлт өөрчлөлт хийх;
  - 4.16.2 Барьцааны хөрөнгө, хураамж, шимтгэл, алдангийн тайланг холбогдох журмын дагуу гаргах;
  - 4.16.3 Клирингийн үйл ажиллагаатай холбоотой журам, харилцагчаа таньж мэдэх үйл ажиллагаа, эрсдэлийг удирдах зөвлөмжөөр Клирингийн гишүүнийг хангаж, сургалт зохион байгуулах;
  - 4.16.4 Хуулиар тогтоосноос бусад тохиолдолд Клирингийн гишүүн болон түүний харилцагчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, нууц алдагдахаас урьдчилан сэргийлэх;
  - 4.16.5 Саатал болон дефолтын мэдээллийг Хороонд тухай бүр хүргүүлэх;
- 4.17 Клирингийн гишүүн дараах эрхтэй. Үүнд:



- 4.17.1 Клиингийн төвөөс клиингийн үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж, тайлбар авах, Клиингийн төвийн зохион байгуулах сургалтад хамрагдах;
- 4.17.2 Харилцагчаа таньж мэдэх судалгаанд үндэслэн харилцагчийн эрсдэлийн маржининг түвшинг тодорхойлох, харилцагчийн маржингиин хувь хэмжээг тогтоох, маржин байршуулахыг шаардах;
- 4.17.3 Төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй харилцагчийн маржин төлбөрт ашиглах, тухайн төлбөрийн үүрэгт хамаарах үнэт цаасыг худалдах;
- 4.17.4 Харилцагчаас клиингийн үйлчилгээний шимтгэл тооцон авах;
- 4.18 Клиингийн гишүүн дараах үүрэгтэй. Үүнд:
- 4.18.1 Гишүүнчлэлийн шалгуур, шаардлагыг тогтмол хангаж ажиллах;
- 4.18.2 Төлбөр гүйцэтгэх өдөрт хамаарах мөнгөн төлбөрийн болон үнэт цаасны шилжүүлгийн бүх үүргийг бүрэн гүйцэтгэх;
- 4.18.3 Харилцагчийн дансны бүртгэлийг үнэн зөв хөтлөх;
- 4.18.4 Энэ журам болон гишүүнчлэлийн гэрээнд заасан барьцаа хөрөнгийг Клиингийн төвийн холбогдох дансанд хугацаанд нь байршуулах;
- 4.18.5 Энэ журамд болон гишүүнчлэлийн гэрээнд заасан Төлбөрийн баталгааны сангийн хуримтлалыг байршуулах, уг сантай холбогдох нөхөн төлбөрийн үүргээ биелүүлэх;
- 4.18.6 Харилцагчаа таньж мэдэх, тухайн харилцагч мөнгө угаах болон терроризмын санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн шаардлагыг хангах хүртэл түүнд үйлчилгээ үзүүлэхгүй байх, харилцагчтай хуулийн хүчин төгөлдөр гэрээ байгуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зурсан байх;
- 4.18.7 Клиингийн үйл ажиллагаатай холбоотой цахим холболт, Клиингийн төвийн системд нэвтрэх нууц үгийн хамгаалалт, аюулгүй байдлыг бүрэн хангах;
- 4.18.8 Клиингийн ерөнхий гишүүний хувьд Клиингийн бус гишүүнтэй шинээр гэрээ байгуулах болон гэрээ дуусгавар болгохоор шийдвэрлэсэн бол тухай бүр Клиингийн төвд нэн даруй мэдэгдэх;
- 4.18.9 Энэ журмаар тогтоосон шимтгэл, хураамж, алдангийг Клиингийн төвөөс нэхэжилсэн хугацаанд нь бүрэн төлөх;
- 4.18.10 Гишүүнчлэлийн эрхийг түдгэлзүүлсэн эсвэл цуцалсан тохиолдолд Клиингийн төвд шаардлагатай мэдээллийг гарган өгч, хамтран ажиллах;
- 4.19 Хорооноос Клиингийн гишүүний зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн эсвэл энэ журмын 4.5-д заасан гишүүнчлэлийн шалгуурыг хангахгүй болсон тохиолдолд Клиингийн төв Клиингийн гишүүний эрхийг түдгэлзүүлнэ.
- 4.20 Клиингийн төв дараах тохиолдолд Клиингийн гишүүний эрхийг цуцална. Үүнд:
- 4.20.1 Хорооноос Клиингийн гишүүний зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;
- 4.20.2 Энэ журамд заасан шалгуур, шаардлагыг биелүүлэх, ханган ажиллах боломжгүй болсон;



- 4.20.3 Клирингийн гишүүнээр элсэх хүсэлт гаргахдаа хуурамч баримт бичиг ашигласан болох нь тогтоогдсон;
- 4.20.4 Гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн;
- 4.20.5 Энэ журмын 7 дугаар бүлэгт заасан дефолт болсон;
- 4.20.6 Төлбөрийн чадваргүй болсон эсвэл төлбөрийн чадваргүй байдалд тооцож болзошгүй нөхцөл бий болсон;
- 4.20.7 Клирингийн гишүүн өөрөө хүсэлт гаргасан;
- 4.21 Клирингийн төв Клирингийн гишүүний эрхийг цуцалсан тухай арилжаа эрхлэх байгууллага, төлбөр гүйцэтгэх байгууллага болон Хороонд нэн даруй мэдэгдэнэ.
- 4.22 Гишүүнчлэлийн гэрээнээс татгалзах эсвэл Гишүүнчлэлийг дуусгавар болгох нь Клирингийн гишүүнийг Гишүүнчлэлтэй байх хугацаанд энэхүү журам болон холбоотой баримт бичгийн дагуу хүлээсэн үүрэг хариуцлага, клирингийн болон төлбөрийн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

### Тав. БАРЬЦАА, МАРЖИН


- 5.1 Клирингийн гишүүн Клирингийн төвийн дансанд мөнгөн хэлбэрээр барьцаа байршуулна. Клирингийн төвөөс тогтоосон нөхцөлийн дагуу үнэт цаас хэлбэрээр барьцаа байршуулж болно.
- 5.2 Клирингийн төв Клирингийн гишүүн бүрээр барьцааны дансны бүртгэл хөтөлнө.
- 5.3 Клирингийн төв Клирингийн гишүүний хэлцлийг үнэт цаас тус бүрээр цэвэршүүлж, энгийн арилжааны үнийн дүнгийн 30 хүртэл хувь, их дүнтэй арилжааны үнийн дүнгийн 50 хүртэл хувиар барьцааны дүнг тодорхойлон T+0 өдөр Клирингийн гишүүнд хүргүүлнэ. Үнэт цаасны төрөл тус бүрийн барьцааны хувь хэмжээг Хорооны саналыг харгалzan Клирингийн төвийн Гүйцэтгэх захирал тогтооно.
- (ТУЗ-ийн 2020 оны 19-р тогтоолоор өөрчлөн найруулсан)
- 5.4 Харилцагч T+0 өдөр худалдан авсан үнэт цаасаа T+1 өдөр буцаан худалдсан нь төлбөрийн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 5.5 Клирингийн гишүүн T+1 өдрийн арилжаа эхлэх цагаас 20 минутын өмнө Клирингийн төвийн дансанд барьцаагаа байршуулна.
- 5.6 Клирингийн гишүүн энэ журмын 5.5-д заасан хугацаанд барьцаа байршуулаагүй тохиолдолд Клирингийн төвөөс холбогдох УЦК-ийн худалдан авах захиалгад хязгаарлалт хийх мэдэгдлийг арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.
- 5.7 Клирингийн гишүүн өөрийн байршуулсан барьцаагаа бүхэлд нь болон хэсэгчлэн төлбөрт ашиглаж болно. Барьцаагаа төлбөрт ашиглах хүсэлтийг Клирингийн гишүүн T+1 өдөрт багтаан Клирингийн төвд илгээх ба Клирингийн төв барьцаа хөрөнгийг төлбөр гүйцэтгэх байгууллагын дансанд T+2 өдрийн тогтоосон хугацаанд шилжүүлнэ.
- 5.8 Клирингийн гишүүний байршуулсан барьцаа нь Клирингийн төвөөс тодорхойлсон барьцааны дүнгээс илүү гарсан тохиолдолд барьцааг буцаан авч болно.



- 5.9 Хэлцлийн үнийн дүн хэт өндөр эсвэл Клирингийн гишүүний төлбөрийн чадварын байдалд эрсдэлтэй нөхцөл байдал бий болсон тохиолдолд Клирингийн төв тухайн өдрийн барьцааны хувь хэмжээ, дунг нэмэгдүүлж болно.
- 5.10 Барьцаа байршуулах зорилгоор Клирингийн төв болон Клирингийн гишүүн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны данс нээнэ.
- 5.11 Мөнгөн хөрөнгийн дансыг Клирингийн гишүүн Монголбанкны үндэсний төлбөрийн системийн оролцогч Клирингийн төвд өөрийн нэрээр нээнэ.
- 5.11<sup>1</sup> Төлбөр тооцоо нь гадаад валютаар илэрхийлэгдсэн үнэт цаасны арилжааны клирингийг гүйцэтгэх зорилгоор Клирингийн төв арилжааны банканд барьцааны данс нээж болно.
- (ТҮЗ-ийн 2021 оны 12-р тогтоолоор нэмэлт орсон)
- 5.12 Үнэт цаасны дансыг Клирингийн төв Хадгаламжийн байгууллагад өөрийн нэрээр нээлгэж, барьцааны болон шаардлагатай бусад үнэт цаасыг хадгална.
- 5.13 Клирингийн гишүүн харилцагчаас үнэт цаасны арилжааны төлбөрийн баталгаа болгон хэлцлийн үнийн дүнгийн тодорхой хувиар маржин авна.

### Зургаа. СААТАЛ

- 6.1 Клирингийн гишүүн түр зуурын техникийн saat, хүлээгдэж буй шилжүүлгээс шалтгаалан мөнгөн төлбөрийн болон үнэт цаасны шилжүүлгийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдлыг saat алгэвэрээс гэж үзнэ.
- 6.2 Мөнгөн төлбөрийн saat гарсан тохиолдолд Клирингийн төв saat төлбөрийг өөрийн зөвшөөрөгдсөн хөрөнгийн эх үүсвэрээр гүйцэтгэж, тухайн saat алдарт хамаарах үнэт цаасыг төлбөр нөхөн төлөгдөх хүртэл өөрийн дансанд шилжүүлэн авах мэдэгдлийг Төлбөр гүйцэтгэх байгууллагад илгээх бөгөөд saat төлбөрийг алдангийн хамт Клирингийн гишүүнээс нэхэмжилнэ.
- 6.3 Үнэт цаасны шилжүүлгийн saat гарсан тохиолдолд Клирингийн төв Үргэлжлэх цэвэр төлбөр (*Continues net settlement*)-ийн аргыг доор дурдсан дарааллаар хэрэгжүүлнэ. Үүнд:
- 6.3.1 Үнэт цаасны шилжүүлгийн saat гарсан даруй Клирингийн төв энэ журмын 3.2.2-т заасан даалгаврыг буцааж, saat үнэт цаасны нийлүүлэлт, түүний төлбөрийг хассан байдлаар даалгаврыг шинэчлэн төлбөр гүйцэтгэх байгууллагад илгээнэ. Төлбөр гүйцэтгэх байгууллага шинэчилсэн төлбөрийн даалгавраар тухайн өдрийн бусад төлбөрийг гүйцэтгэнэ.
- 6.3.2 Клирингийн төв үнэт цаасны шилжүүлгийн saatлиг хүлээн зөвшөөрч, saat үнэт цаасны мөнгөн төлбөрийг Үргэлжлэх цэвэр төлбөрийн дүнгээр хүлээн авах саналыг клирингийн гишүүдэд хүргүүлнэ.
- 6.3.3 Үргэлжлэх цэвэр төлбөрийн дүн нь нийлүүлээгүй үнэт цаасны тоо ширхгийг тухайн үнэт цаасны хаалтын ханшаар үргүүлсэнтэй тэнцүү байна.
- 6.3.4 Үргэлжлэх цэвэр төлбөрийг хүлээн авсан Клирингийн гишүүн T+3 өдөр saat үнэт цаасыг шилжүүлэх үүрэг хүлээнэ.
- 6.3.5 Энэ журмын 6.3.2-д заасан саналыг хүлээн авах Клирингийн гишүүн олдоогүй тохиолдолд saat гаргасан гишүүнийг дефолт болсонд тооцно.




- 6.3.6 Үнэт цаасны шилжүүлгийн saatlyн үүргийг дараа өдрийн арилжааны үр дүнд цэвэршүүлсэн тохиолдолд энэ журмын 6.3.4, 6.3.5-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагагүй.
- 6.4 Хэрэв энэ журмын 6.3.4-т заасан шилжүүлэх үүрэг T+3 өдөр хангагдаагүй бол saatсан үнэт цаасыг хүлээн авах Клирингийн гишүүн тухайн үнэт цаасыг зах зээл дээрээс худалдан авах (*Buy-in*) хүсэлтийг Клирингийн төвд тавьж болно.
- 6.5 Энэ журмын 6.4-т заасан хүсэлтийн дагуу Клирингийн төв нийлүүлэгдээгүй үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагын онцгой арилжаагаар худалдан авна.
- 6.6 Энэ журмын 6.5-д заасан худалдан авалтын даалгаврыг Төлбөр гүйцэтгэх байгууллагад өгөх ба Төлбөр гүйцэтгэх байгууллага нь шилжүүлгийг тухайн өдөртөө эцсийн хөрөнгө оруулагчдын хооронд гүйцэтгэнэ.
- 6.7 Энэ журмын 6.5-д заасан худалдан авалтыг хийхэд Үргэлжлэх цэвэр төлбөрийн аргыг ашиглана.
- 6.8 Үнэт цаасны шилжүүлгийн saataltай холбоотой гарсан ханшийн өөрчлөлтийн болон бусад нэмэлт зардал, алдангийг saatал гаргасан Клирингийн гишүүн хариуцна.

#### **Долоо. ДЕФОЛТ, ДЕФОЛТЫН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

- 7.1 Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан нөхцөл байдлаас гадна дараах тохиолдлыг гишүүнд дефолт үүссэн гэж үзнэ. Үүнд:
- 7.1.1 Энэ журам болон гишүүнчлэлийн гэрээний дагуу төлөх шаардлагатай аливаа төлбөрийн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй эсвэл эдгээр үүргээ гүйцэтгэх боломжгүй тухайгаа илэрхийлсэн;
- 7.1.2 Энэ журмын 6.2-т заасан saatсан төлбөрийг нэхэмжилсэн хугацаанд нь буцаан төлөөгүй;
- 7.1.3 Энэ журмын 6.3.5-д заасан нөхцөл байдал бий болсон;
- 7.1.4 Клирингийн төвийн зүгээс Клирингийн гишүүний төлбөрийн чадвар, санхүүгийн нөхцөл байдалд ноцтой өөрчлөлт орсон гэж үзсэн;
- 7.2 Энэ журмын 7.1-д заасан нөхцөл байдал үүссэн бол Клирингийн төв нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, энэ журам болон гишүүнчлэлийн гэрээний дагуу өөрт олгогдсон бүх эрхийг хэрэгжүүлэх ба тухайн үүссэн нөхцөл байдалд нийцүүлэн дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:
- 7.2.1 Хороо, арилжаа эрхлэх байгууллага, төлбөр гүйцэтгэх байгууллага, бүх гишүүнд энэ тухай өдөр, цагийг тодорхой заасан мэдэгдэл хүргүүлэх;
- 7.2.2 Дефолт болсон гишүүний Клирингийн төвийн системд нэвтрэх эрхийг хаах;
- 7.2.3 Дефолт болсон гишүүний арилжаа эрхлэх байгууллагын захиалгын санд оруулсан захиалгыг цуцлуулах;
- 7.2.4 Дефолт болсон гишүүний төлбөл зохих төлбөрийн дүнг тодорхойлох, гишүүний дансны үлдэгдлийг үнэлэх;
- 7.2.5 Төлбөр нь хийгдээгүй үнэт цаасыг Клирингийн төвийн дансанд шилжүүлэн авах мэдэгдлийг Төлбөр гүйцэтгэх байгууллагад илгээх, Клирингийн төвийн тодорхойлсон хэлбэрээр үнэт цаасыг худалдах;



- 7.2.6 Энэ журмын дефолтын дэс дараалал хэсэгт заасан арга **улхэмжээг хот хэрэгжүүлэх**;
- 7.2.7 Дефолт зарласнаас үүссэн аливаа асуудалтай холбогдуулан төвийн зүгээс шаардлагатай гэж үзсэн хууль зүйн болон зөвлөгөө туслалцааг дефолт болсон гишүүний зардлаар авах;
- 7.2.8 Төлбөрийн баталгааны сангийн зөвлөлийг хуралдуулан мэдээлэл өгөх,
- 7.3 Хоёр болон түүнээс дээш гишүүн дефолт болсон тохиолдолд зах зээлийг нийтэд нь хамарсан дефолт гэж үзэн Клиингийн төв дараах арга хэмжээг авна. Үүнд:
- 7.3.1 Энэ тухай Хороо болон бүх оролцогчдод нэн даруй мэдэгдэх;
- 7.3.2 Шаардлагатай тохиолдолд үнэт цаасны арилжааг түр зогсоож саналыг арилжаа эрхлэх байгууллага хүргүүлэх, клиингийн үйл ажиллагааг түр зогсоож, энэ тухай нийтэд мэдээлэх;
- 7.3.3 Нөхцөл байдал тогтвортжсоны дараа үндсэн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх бэлтгэлийг хангасны үндсэн дээр арилжаа, клиингийн үйл ажиллагааг дахин эхлүүлэх, энэ тухай нийтэд мэдээлэх;
- 7.4 Клиингийн төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу Хороо, Монголбанк, арилжаа эрхлэх байгууллага, төлбөр гүйцэтгэх байгууллага болон дефолт болсон гишүүнтэй холбоотой аливаа байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцно.
- 7.5 Дефолт болсон Клиингийн гишүүн нь Клиингийн төвтэй үнэнч шударгаар хамтран ажиллах ба нөхцөл байдалтай холбоотой Клиингийн төвөөс бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь бүх талаар дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
- 7.6 Дефолт болсон Клиингийн гишүүнээс бусад гишүүн дефолтын үед Клиингийн төвтэй үнэнч шударгаар хамтран ажиллах ба Клиингийн төвийн гаргасан үндэслэл бүхий хүсэлт, шаардлагыг хүлээн авч хамтран ажиллана.
- 7.7 Дефолт болсон Клиингийн гишүүний өглөг, авлагын “Эхний тооцоолол”-ыг дараах аргаар тодорхойлно. Үүнд:
- 7.7.1 Клиингийн гишүүний өөрийн дансны үндсэн төлбөрийн дүнг тодорхойлох;
- 7.7.2 Клиингийн гишүүн нэгээс дээш өөрийн данстай байвал бүх дансны үлдэгдлийг нэгтгэн үндсэн төлбөрийн дүнг тодорхойлох;
- 7.7.3 Клиингийн гишүүний харилцагчийн хувьд харилцагч бүрээр тооцоолол хийж, тус тусад нь үндсэн төлбөрийн дүнг тодорхойлох;
- 7.8 Энэ журмын 7.7-д заасны дагуу Эхний тооцоолол гаргахад гишүүний өөрийн данс авлагатай, харилцагчийн данс өглөгтэй бол Клиингийн төв харилцагчийн дансны өглөгийг Клиингийн гишүүний авлагаар хааж эсвэл хасч тооцож болно.
- 7.9 Энэ журмын 7.7-д заасны дагуу Эхний тооцоолол гаргахад харилцагчийн данс авлагатай бол уг авлагаар Клиингийн гишүүний өөрийн дансны өглөгийг хааж эсвэл хасч тооцохыг хориглоно.
- 7.10 Клиингийн төв энэ журмын 7.7, 7.8, 7.9-д заасан тооцооллыг үндэслэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:



- 7.10.1 Харилцагчийн төлбөрийн дүн эерэг гарвал харилцагч авлагатай буюу уг дүнг дефолт болсон Клирингийн гишүүнд эсвэл түүний эрх хүлээн авагчид шилжүүлнэ.
- 7.10.2 Харилцагчийн төлбөрийн дүн сөрөг гарвал харилцагч өглөгтэй буюу дефолт болсон Клирингийн гишүүн эсвэл харилцагч уг дүнг нэн даруй төлнө. **ХХК**
- 7.10.3 Дефолт болсон Клирингийн гишүүний өөрийн дансны төлбөрийн дүн эерэг гарвал Клирингийн гишүүн авлагатай буюу дефолт болсон Клирингийн гишүүнд эсвэл түүний эрх хүлээн авагчид уг дүнг шилжүүлнэ.
- 7.10.4 Дефолт болсон Клирингийн гишүүний өөрийн дансны төлбөрийн дүн сөрөг гарвал өглөгтэй буюу дефолт болсон Клирингийн гишүүн нэн даруй төлнө.
- 7.11 Энэ журмын 7.10.1 болон 7.10.3 дахь заалтууд буюу дефолт болсон талд төлөх төлбөрийг шилжүүлэхээс өмнө Клирингийн төв энэ журамд заасан бүх эрхээ хэрэгжүүлсэн байх ба дефолт болсон Клирингийн гишүүнтэй Анхны тооцооллыг баталгаажуулан тооцоо нийлсэн акт үйлдэнэ.
- 7.12 Энэ журмын 7.10.2 болон 7.10.4 дэх заалтууд буюу өглөгийн нийлбэр дүнг *Дефолтын төлбөр* гэх бөгөөд Дефолт болсон Клирингийн гишүүний Төлбөрийн баталгааны санд оруулсан хуримталаас хасч барагдуулна.
- 7.13 Энэ журмын 7.12-р заалтыг хэрэгжүүлсэн боловч дефолт болсон Клирингийн гишүүн өглөгийн үлдэгдэлтэй байвал уг өглөгийг *Дефолтын дутсан дүн* гэх бөгөөд Клирингийн төвийн Төлбөрийн баталгааны санд оруулсан хөрөнгө болон дефолт болоогүй бусад Клирингийн гишүүний Төлбөрийн баталгааны санд оруулсан хөрөнгөөс барагдуулна.
- 7.14 Клирингийн төв дефолт болсон Клирингийн гишүүний *Эхний тооцоолол, Дефолтын төлбөр, Дефолтын дутсан дүнгийн төлсөн эсвэл төлөгдсөн гүйлгээг холбогдох журмын дагуу Клирингийн төвийн тайланд тусгах бөгөөд уг тайлан нь энэ журмын 7.10-д тодорхойлсон үйл ажиллагааны нотлох баримтад тооцогдоно.*
- 7.15 Дефолтын үед үүссэн алдагдлыг Клирингийн төв барьцаа хөрөнгө болон Төлбөрийн баталгааны сангийн хөрөнгөөс дараах дарааллаар захиран зарцуулна. **Үүнд:**
- 7.15.1 дефолт болсон Клирингийн гишүүний байршуулсан бүх барьцаа;
  - 7.15.2 дефолт болсон Клирингийн гишүүний байршуулсан төлбөрийн баталгааны сангийн хуримтлал;
  - 7.15.3 дефолтын үед ашиглах Клирингийн төвийн хөрөнгийн эхний хэсэг;
  - 7.15.4 дефолтод хамааралгүй Клирингийн гишүүний байршуулсан төлбөрийн баталгааны сангийн хуримтлал;
  - 7.15.5 дефолтын үед ашиглах Клирингийн төвийн хөрөнгийн нэмэлт хэсэг;
  - 7.15.6 Клирингийн төв болон Клирингийн гишүүнээс хувь тэнцүүлэн дахин татан төвлөрүүлсэн хөрөнгө.
- 7.16 Дефолтын үед авах арга хэмжээний дарааллыг энэ журмын 7.15-д заасны дагуу хэрэгжүүлэх тухай Клирингийн төвийн шийдвэрийг бүх Клирингийн гишүүн хүлээн зөвшөөрнө. Бусад хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Клирингийн төв

өөрийн санаачилгаар өөрт учрах эрсдэлийг бууруулах боломжтой гэж үзсэн аргаар энэ журмын 7.15-д заасан нөөцийг ашиглах эрхтэй.

- 7.17 Дефолтын үед энэ журмын 7.15-д заасан дарааллаар эрсдэлийг хаасан нь дефолт болсон Клирингийн гишүүнийг Төлбөрийн баталгааны сангийн нөхөн бүрдүүлэлт болон бусад үүргээс чөлөөлөхгүй.



## Найм. ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ САН


- 8.1 Төлбөрийн баталгааны сан нь Клирингийн төвийн хөрөнгийн нэмэлт хэсэг болон Клирингийн гишүүний хуримтлалаас бүрдэх бөгөөд зөвхөн дефолтын үед ашиглах зориулалттай сан байна.
- 8.2 Төлбөрийн баталгааны сангийн хөрөнгийг энэ журмын 8.1-д заасан болон Төлбөрийн баталгааны сангийн хөрөнгийг өсгөх зорилгоор явуулах үйл ажиллагаанаас өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.
- 8.3 Клирингийн төв Төлбөрийн баталгааны санд байршуулсан хуримтлалыг клирингийн гишүүн тус бүрээр бүртгэл хөтлөх ба Төлбөрийн баталгааны сангийн хөрөнгө Клирингийн төв санхүүгийн тайланд өглөгөөр тусгагдана.
- 8.4 Төлбөрийн баталгааны сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
- 8.4.1 Клирингийн төвийн хөрөнгийн нэмэлт хэсэг;
  - 8.4.2 Клирингийн гишүүний байршуулах суурь хуримтлал;
  - 8.4.3 Клирингийн гишүүний байршуулах нэмэлт хуримтлал;
- 8.5 Дараах асуудлаар шийдвэр гаргах үүрэгтэй Төлбөрийн баталгааны сангийн зөвлөл (цаашид “Сангийн зөвлөл” гэх) ажиллана. Үүнд:
- 8.5.1 Төлбөрийн баталгааны санд Клирингийн гишүүний байршуулах суурь болон нэмэлт хуримтлалын хэмжээг тогтоох;
  - 8.5.2 Төлбөрийн баталгааны сангийн хөрөнгийг үр ашигтай, аюулгүй хэлбэрээр байршуулах;
  - 8.5.3 Төлбөрийн баталгааны сангийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, нөхөн бүрдүүлэлтэд хяналт тавих.
- 8.6 Сангийн зөвлөл нь Клирингийн төв, мэргэжлийн холбооны тус бүр 2 төлөөлөл, Хороо, арилжаа эрхлэх байгууллага, төлбөр гүйцэтгэх байгууллагын тус бүр 1 төлөөлөл, нийт 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Сангийн зөвлөлийн даргыг Клирингийн төвийн төлөөллөөс томилно.
- 8.7 Төлбөрийн баталгааны сангийн хөрөнгийг өсгөх зорилгоор нийт хуримтлалын 50 хүртэлх хувиар Засгийн газар, Монголбанкны өрийн хэрэгсэл худалдан авах, арилжааны банкны хадгаламжид байршуулах шийдвэр гаргаж болно.
- 8.8 Энэ журмын 8.7-д заасан үйл ажиллагаанаас орсон орлогыг санхүүгийн жилийн эцэст Клирингийн төв болон Клирингийн гишүүний Төлбөрийн баталгааны санд байршуулсан хөрөнгийн дүнд хувь тэнцүүлэн бүртгэнэ.
- 8.9 Клирингийн гишүүний эрсдэл нэмэгдсэн гэж Клирингийн төвөөс үзсэн тохиолдолд Клирингийн төв тухайн Клирингийн гишүүний Төлбөрийн баталгааны сангийн нэмэлт хуримтлалын хэмжээг дахин тооцоолж, нэн даруй байршуулахыг шаардана.



- 8.10 Клирингийн нэг гишүүний Төлбөрийн баталгааны санд оруулах хуримтлалын дээд хэмжээ нийт Төлбөрийн баталгааны сангийн 50 хувиас хэтрэхгүй байна.
- 8.11 Сангийн зөвлөл Төлбөрийн баталгааны санд байршуулах хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтооход хуримтлалын хэмжээ буурсан бол зөрүүг Клирингийн гишүүнд буцаан олгоно.
- 8.12 Төлбөрийн баталгааны санд байршуулсан нэг Клирингийн гишүүний хуримтлалын хэмжээ сангийн нийт хөрөнгийн 50 хувьд хүрсэн бол уг гишүүнээс нэмэлт хуримтлал авахыг түр зогсоон.
- 8.13 Төлбөрийн баталгааны санг энэ журмын 7 дугаар бүлэгт заасны дагуу Клирингийн төв бүхэлд нь эсвэл хэсэгчлэн захиран зарцуулна.
- 8.14 Клирингийн төв нь нэг буюу түүнээс дээш удаа дефолт зарласнаас шалтгаалан учирч болзошгүй бүх зардал, хохирол, алдагдлын эсрэг өөрийгөө хамгаалахын тулд Төлбөрийн баталгааны санг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн шаардлагатай үед хэдэн ч удаа ашиглах эрхтэй.
- 8.15 Төлбөрийн баталгааны сангийн ўйл ажиллагааны зардлыг Клирингийн гишүүн бүрт тэнцүү хуваарилах ба сарын нийт ўйл ажиллагааны зардал нь Төлбөрийн баталгааны санд хуримтлагдсан хөрөнгийн 0.1 хувиас хэтрэхгүй байна.
- 8.16 Төлбөрийн баталгааны сангаас гарсан хөрөнгийг дефолт болсон Клирингийн гишүүнээс нэхэмжлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 8.17 Нэхэмжлэлийн дагуу төлөгдсөн хөрөнгөөр Төлбөрийн баталгааны санг дараах дарааллаар нөхөн бүрдүүлнэ. Үүнд:
  - 8.17.1 Энэ журмын 7.15.6-д заасан хөрөнгө
  - 8.17.2 Энэ журмын 7.15.4-д заасан хөрөнгө
  - 8.17.3 Энэ журмын 7.15.5-д заасан хөрөнгө
  - 8.17.4 Энэ журмын 7.15.3-д заасан хөрөнгө
  - 8.17.5 Энэ журмын 7.15.2-д заасан хөрөнгө
- 8.18 Дефолт болсон Клирингийн гишүүн нэхэмжилсэн хөрөнгийг бүрэн бус, хэсэгчлэн төлсөн бол дефолт болоогүй Клирингийн гишүүдийн санд оруулсан анхны дүнгээр хувь тэнцүүлэн хуваарилж бүртгэнэ.
- 8.19 Хэрэв дефолт болсон Клирингийн гишүүн нэхэмжилсэн хөрөнгийг төлөөгүй бол дефолтод хамааралгүй Клирингийн гишүүн бүр энэ журамд заасны дагуу Төлбөрийн баталгааны санг дахин бүрдүүлнэ.

#### Ес. БУСАД

- 9.1 Клирингийн гишүүн нь хавсралт 1-д заасан гишүүнчлэлийн элсэлтийн болон жилийн хураамж, клирингийн үйлчилгээний шимтгэл төлнө. Шинээр элссэн гишүүн 1 жилийн хугацаанд жилийн хураамж төлөхгүй.
- 9.2 Клирингийн гишүүний гишүүнчлэл цуцлагдсан нь элсэлтийн болон тухайн жилийн хураамжийг буцаан олгох үндэслэл болохгүй.



- 9.3 Мөнгөн төлбөрийн эсвэл үнэт цаасны шилжүүлгийн саатал гарсан тохиолдолд Клирингийн гишүүн мөнгөн төлбөр эсвэл үнэт цаасны шилжүүлэг хоцроосны алдангийг гэрээний дагуу Клирингийн төвд төлнө. Алдангийн хувь хэмжээг Клирингийн төв тогтооно.
- 9.4 Энэ журмын заалтыг зөрчсөн Клирингийн гишүүнд гэрээний дагуу хариуцлага ногдуулна.
- 9.5 Дефолт болсон Клирингийн гишүүний барьцаа болон бусад хөрөнгө түүний Клирингийн төвд учруулсан хохирлыг барагдуулахад хүрэлцэхгүй тохиолдолд Клирингийн төв шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

УЛАНБААТАР ХОТ  
Хавсралт 1  
  
ҮНЭТ ЦАЛСНЫ  
ХУДАЛДАН АВСАН  
ХУГАЦГИЙН ТӨВ  
Тайлбар  
ХХК  
9020040109  
ХТУ4426 Ⓛ 6051804

## ГИШҮҮНЧЛЭЛИЙН ХУРААМЖ, КЛИРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШИМТГЭЛ

№	Хураамж, шимтгэлийн төрөл	Хэмжих нэгж	Хувь хэмжээ	Тайлбар
1	Гишүүнчлэлийн хураамж			
1.1	Элсэлтийн хураамж	Төгрөг	10,000,000	Нэг удаа
1.2	Жилийн хураамж	Төгрөг	1,000,000	Жил бүр
2	Клирингийн үйлчилгээний шимтгэл**			
2.1	Хувьцаа	Хувь	0.12***	Худалдсан болон худалдан авсан үнийн дүн тус бүрээс***
2.2	Засгийн газрын бонд	Хувь	0.00375	
2.3	Компанийн бонд	Хувь	0.0075	

\*ТҮЗ-ийн 2020 оны 13-р тогтоолоор өөрчлөн найруулсан.

\*\*ТҮЗ-ийн 2020 оны 19-р тогтоолоор өөрчлөн найруулсан

\*\*\*ТҮЗ-ийн 2021 оны 01-р тогтоолоор өөрчлөн найруулсан.